



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/9/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас: 51-260512, Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 51-260512, Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 51-261628, Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: М.Ганбаатар
Утас: 51-261628, Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал.....	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал, хууль эрх зүйн орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төсвийн ерөнхийлөн захирагч	24
5.1.1. Зөвлөмж.....	24
5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ, ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2026.04.24 № 1124
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Прокурорын үүрэг, оролцооны хувьсал: цахим орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэх сорилт, сайн туршлага” сэдэвт Олон Улсын Прокурорын холбооны Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн 10 дугаар хурлыг Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгуулсан байна. Тус хуралд Америкийн Нэгдсэн Улс, Англи, Канад, Австрали, Румын, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Турк, Саудын Араб, Кувейт, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг нийт 25 улсын прокурорын байгууллагын 100 гаруй төлөөлөгч оролцсон байна.

Уг хурлыг зохион байгуулахад Засгийн газрын нөөц сангаас 1,679.2 сая төгрөгийг гарган зарцуулсан бөгөөд байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас нэмж 543.1 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад баталсан Булган аймгийн прокурорын газрын конторын барилга 2,091.1 сая төгрөг, Сүхбаатар аймгийн прокурорын газрын барилга 3,975.7 сая төгрөгийн барилгын ажлууд дуусгавар болж, улсын комисс хүлээн авсан байна. Тайлант онд Эрүүгийн хэргийн тусгай архивын конторын барилга 9,498.6 сая төгрөг, Дүүргүүдийн нэгдсэн барилга 18,875.2 сая төгрөгийн санхүүжилтийг авснаар барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Прокурор эрүүгийн 2717 хэргийн шүүх хуралдаанд төр, нийтийн ашиг сонирхол, учирсан 8,727.3 сая төгрөгийн хохирлыг гэм буруутай этгээдээс гаргуулах хууль зүйн дүгнэлт гаргаснаас шүүх 8,298.3 сая төгрөгийн хохирол, иргэний нэхэмжлэхийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлүүлсэн нь өмнөх оноос 21.4 хувиар өссөн байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн сүүлийн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хийх ажлын талаар зөвлөмж гарган хэрэгжилтийг бүрэн хангах, ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авснаар хэрэгжилт 81.6 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,310,490.1	46,602,898.4
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,834,432.9	3,010,936.7
3	АВЛАГА	586,872.3	1,040,015.6
4	УРЬДЧИЛГАА	169,406.1	26,945.5
5	БАРАА МАТЕРИАЛ	2,836,759.0	2,875,430.5
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	13,883,019.9	39,649,570.1
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	75,583,016.0	78,116,868.6
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	75,583,016.0	78,116,868.6
9	Биет хөрөнгө	71,303,784.5	73,331,756.5
10	Биет бус хөрөнгө	4,279,231.5	4,785,112.1
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	97,893,506.1	124,719,767.0
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,037,381.3	3,095,818.4
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,949,317.4	3,032,904.3
14	Өглөг	49,630.0	321,916.4
15	Урьдчилж орсон орлого	3,899,687.4	2,710,987.9
16	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	88,063.9	62,914.1
17	Урт хугацаат зээл	88,063.9	62,914.1
18	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	93,856,124.8	121,623,948.6
19	Засгийн газрын хувь оролцоо	93,856,124.8	121,623,948.6
20	Засгийн газрын оруулсан капитал	16,772,925.2	16,898,806.6
21	Хуримтлагдсан үр дүн	72,363,036.7	100,006,069.1
22	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,720,163.0	4,719,072.9
23	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	97,893,506.1	124,719,767.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	111,812,548.6	151,429,065.4
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,140,177.2	151,429,065.4
3	Тусламжийн орлого	-	148,234,692.9
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,672,371.4	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	101,531,315.5	123,371,209.9
6	УРСГАЛ ЗАРДАЛ	101,531,315.5	123,371,209.9
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,548,832.4	118,772,864.6
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,217,822.6	89,492,473.9
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,539,205.8	11,173,993.1
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,700,190.0	1,970,471.7
11	Хангамж, бараа материалын зардал	2,674,356.2	3,058,303.0
12	Нормативт зардал	121,061.3	102,534.5
13	Эд хогшил, урсгал засварын зардал	1,888,212.4	1,232,341.8
14	Томилолт, зочны зардал	386,540.4	264,191.6
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,816,104.5	1,650,043.8
16	Бараа үйлчилгээний бусад зардал	7,205,339.3	9,828,511.4
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,982,483.1	4,598,345.4
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,281,233.1	28,057,855.4
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	166,544.0	380,460.0
20	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(166,544.0)	(380,460.0)
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	10,114,689.1	27,677,395.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	113,992,112.3	150,707,356.4
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,992,112.3	150,707,356.4
3	Нийтлэг татварын бус орлого	3,319,740.9	2,448,555.4
4	Тусламжийн орлого		148,258,801.0
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,672,371.4	-
6	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,859,500.1	120,838,511.3
7	УРСГАЛ ЗАРДАЛ	98,859,500.1	120,838,511.3
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,628,850.6	112,945,315.3
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,266,244.4	89,487,550.6
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,520,408.3	11,172,748.3
11	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,706,643.6	1,972,108.4
12	Хангамж, бараа материалын зардал	2,487,205.5	2,511,148.2
13	Нормативд зардал	200,000.0	56,392.0
14	Эд хогшил, урсгал засварын зардал	3,719,991.4	1,540,217.1
15	Томилолт, зочны зардал	395,822.7	264,476.6
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,227,438.9	2,485,327.3
17	Бараа үйлчилгээний бусад зардал	2,105,095.7	3,455,346.7
18	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,230,649.5	7,893,196.0
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,132,612.3	29,868,845.1
20	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	12,076,382.3	31,693,124.3
21	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,076,382.3	31,693,124.3
22	Дотоод эх үүсвэрээр	12,076,382.3	31,693,124.3
23	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,076,382.2)	(31,693,124.3)
24	Бусад эх үүсвэр	226.6	991.7
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	186.4	208.7
26	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	40.2	782.9
27	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,056,270.2	(1,823,496.3)
28	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,778,162.8	4,834,432.9
29	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,834,432.9	3,010,936.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,252,656.6		83,252,656.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	488,379.1		488,379.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,741,035.7		83,741,035.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	399.9		399.9
5	Тайлант үеийн үр дүн	10,114,689.1		10,114,689.1
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,856,124.8		93,856,124.8
7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,856,124.8		93,856,124.8
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-34,362.9		-34,362.9
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,821,761.9		93,821,761.9
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	32,272.8		32,272.8
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	92,518.4		92,518.4
12	Тайлант үеийн үр дүн	27,677,395.4		27,677,395.4
13	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	121,623,948.6		121,623,948.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	145,718,394,300.00	142,671,236,231.54	3,047,158,068.46	97.9
12	Татварын бус орлого	145,718,394,300.00	142,671,236,231.54	3,047,158,068.46	97.9
122	Тусламжийн орлого	145,718,394,300.00	142,671,236,231.54	3,047,158,068.46	97.9
122005	Төсвөөс санхүүжих	145,718,394,300.00	142,671,236,231.54	3,047,158,068.46	97.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145,718,394,300.00	142,671,236,231.54	3,047,158,068.46	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,880,094,300.00	112,834,838,351.54	3,045,255,948.46	97.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,947,627,400.00	111,166,887,328.33	2,780,740,071.67	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,901,879,000.00	89,026,098,178.43	1,875,780,821.57	97.9
210101	Үндсэн цалин	46,434,475,700.00	51,831,957,435.59	(5,397,481,735.59)	111.6
210102	Нэмэгдэл	32,444,818,000.00	28,223,485,333.31	4,221,332,666.69	87.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,565,252,400.00	4,805,261,741.26	759,990,658.74	86.3
210104	Урамшуулал	6,457,332,900.00	4,165,393,668.27	2,291,939,231.73	64.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,655,224,600.00	11,120,059,440.60	535,165,159.40	95.4
210201	Тэтгэврийн даатгал	7,925,995,400.00	7,537,818,086.61	388,177,313.39	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	932,697,200.00	907,853,905.74	24,843,294.26	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	467,306,800.00	459,588,136.08	7,718,663.92	98.3
210204	Ажилгүйдлийн даатгал	465,804,000.00	451,353,990.15	14,450,009.85	96.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,863,421,200.00	1,763,445,322.02	99,975,877.98	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,121,629,500.00	1,972,108,349.66	149,521,150.34	93.0
210301	Гэрэл, цахилгаан	722,240,800.00	623,660,566.96	98,580,233.04	86.4
210302	Түлш, халаалт	1,179,335,700.00	1,173,457,596.90	5,878,103.10	99.5
210303	Цэвэр, бохир ус	174,859,300.00	153,268,565.80	21,590,734.20	87.7
210304	Байрны түрээс	45,193,700.00	21,721,620.00	23,472,080.00	48.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,586,578,700.00	2,472,049,400.88	114,529,299.12	95.6
210401	Бичиг хэрэг	777,730,900.00	696,874,857.35	80,856,042.65	89.6
210402	Тээвэр, шатахуун	527,648,900.00	527,098,261.30	550,638.70	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	653,175,300.00	609,656,589.05	43,518,710.95	93.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,905,500.00	41,321,241.18	12,584,258.82	76.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	574,118,100.00	597,098,452.00	(22,980,352.00)	104.0
2105	Нормативт зардал	57,801,200.00	56,392,000.00	1,409,200.00	97.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	57,801,200.00	56,392,000.00	1,409,200.00	97.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,377,052,300.00	2,364,713,760.00	12,338,540.00	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	982,655,100.00	973,176,730.00	9,478,370.00	99.0
210604	Урсгал засвар	1,394,397,200.00	1,391,537,030.00	2,860,170.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	242,197,100.00	232,462,920.00	9,734,180.00	96.0
210702	Дотоод албан томилолт	242,197,100.00	232,462,920.00	9,734,180.00	96.0

Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,469,217,300.00	2,417,797,781.97	51,419,518.03	97.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,464,801,500.00	1,436,027,488.43	28,774,011.57	98.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,897,900.00	3,648,600.00	11,249,300.00	24.5
210803	Даатгалын үйлчилгээ	220,362,800.00	220,362,000.00	800.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,471,200.00	27,696,175.54	4,775,024.46	85.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,865,600.00	2,119,434.00	746,166.00	74.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	695,641,100.00	692,681,747.00	2,959,353.00	99.6
210807	Газрын төлбөр	38,177,200.00	35,262,337.00	2,914,863.00	92.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,536,047,700.00	1,505,205,496.79	30,842,203.21	98.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,101,531,600.00	1,070,712,366.19	30,819,233.81	97.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	434,516,100.00	434,493,130.60	22,969.40	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,932,466,900.00	1,667,951,023.21	264,515,876.79	86.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,932,466,900.00	1,667,951,023.21	264,515,876.79	86.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,285,964,300.00	1,283,111,223.25	2,853,076.75	99.8
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	247,614,600.00	243,971,799.96	3,642,800.04	98.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	398,888,000.00	140,868,000.00	258,020,000.00	35.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,838,300,000.00	29,836,397,880.00	1,902,120.00	100.0
220001	Барилга байгууламж	26,038,700,000.00	26,036,868,680.00	1,831,320.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	3,799,600,000.00	3,799,529,200.00	70,800.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	44	44	-	100.0
610001	Төсвийн байгууллага	44	44	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1370	1279	91	93.4
620001	Удирдах ажилтан	53	52	1	98.1
620002	Гүйцэтгэх ажилтан	842	756	86	89.8
620003	Үйлчлэх ажилтан	475	471	4	99.2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1370	1315	55	96.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	309	265	44	85.8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	341	341	-	100.0
650012	Шүүгч, прокурор	595	588	7	98.8
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	125	121	4	97.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		2,784,518,854.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,784,518,854.33
122	Тусламжийн орлого		2,784,518,854.33
1221	Хандив тусламж /дотоод/		2,784,518,854.33
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,784,518,854.33
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		94,189,489.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,626,863,503.84
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		58,465,861.49
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,783,422,217.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,783,422,217.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,782,422,217.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		431,892,495.57
210101	Үндсэн цалин		751,126.72
210102	Нэмэгдэл		291,288,050.23
210104	Урамшуулал		124,261,137.46
210105	Гэрээт ажлын хөлс		15,592,181.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		52,688,903.76
210201	Тэтгэврийн даатгал		39,241,416.61
210202	Тэтгэмжийн даатгал		3,553,635.48
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,869,365.44
210204	Ажилгүйдлийн даатгал		1,626,163.28
210205	Эрүүл мэндийн даатгал		6,398,322.95
2104	Хангамж, бараа материалын зардал		17,691,400.00
210401	Бичиг хэрэг		4,141,400.00
210402	Тээвэр, шатахуун		8,550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		180,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		97,800,000.00
210602	Тавилга		10,000,000.00
210604	Урсгал засвар		72,480,000.00
2107	Томилолт, зочны зардал		22,233,640.00
210702	Дотоод албан томилолт		22,233,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		260,554,849.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		260,554,849.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,817,080,929.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,803,080,929.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		1,096,637.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(1,096,637.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(1,096,637.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Прокурорын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн” гэж тодорхойлсон байна.

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг тайлант онд баталж, дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах;
- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Прокурорын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох;
- Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх.

Дээрх зорилгыг хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт;
- Шүүхэд төрийг төлөөлөх;
- Төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах;
- Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- Сургалт, судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал, хууль эрх зүйн орчин

Прокурорын байгууллага үйл ажиллагаандаа Прокурорын хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал болон салбарын бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн. Тухайлбал, төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан;

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилд, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,826.3 сая төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,834.4	3,010.9	(1,823.5)
Авлага	586.9	1,040.0	453.1
Урьдчилгаа	169.4	26.9	(142.5)
Бараа материал	2,836.8	2,875.4	38.6
Бусад эргэлтийн хөрөнгө	13,883.0	39,649.6	25,766.6
Үндсэн хөрөнгө	75,583.0	78,116.9	2,533.9
Нийт хөрөнгө	97,893.5	124,719.8	26,826.3
Өр төлбөр	4,037.4	3,095.8	(941.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	93,856.1	121,623.9	27,767.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	97,893.5	124,719.8	26,826.3

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад нөлөө бүхий материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,010.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,823.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	4,834.4	3,010.9	(1,823.5)
Төгрөг	4,814.8	2,990.5	(1,824.3)
Төрийн сангийн харилцах	4,814.8	2,990.5	(1,824.3)
Гадаад валют	19.6	20.4	0.8
Төрийн сангийн харилцах		20.4	0.8
Бусад төсөл, нөөцийн харилцах	19.6		0.0
Дүн	4,834.4	3,010.9	(1,823.5)

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн данс нь банканд байршиж буй гадаад валютаарх 20.4 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын техник хяналт, хөрөнгө оруулалтын барьцаа 286.5 сая төгрөгийн, эрүүгийн болон зөрчлийн хэргийн барьцааны 2,704.0 сая төгрөгийн, нийт 3,010.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Булган аймгийн прокурорын газар нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэл, шийдвэргүйгээр 0.3 сая төгрөгийг илүү тооцож олгосон;
- Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар нь 0.4 сая төгрөгийг анхан шатны баримт дээр хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсгийг зуруулаагүй, удирдлагаар хянаж баталгаажуулаагүй;
- Ховд аймгийн Булган сумын прокурорын газар нь 2 ажилтанд даргын Б/16 тоот тушаалаар ур чадварын нэмэгдлийг 0.2 сая төгрөгөөр илүү олгосон, цагийн бүртгэл, жолоочийн замын хуудас, албан томилолтоор ажилласан илтгэх зэрэг санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу;
- Ховд аймгийн прокурорын газар нь Б/177 дугаар тушаалаар Тамгын хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэсэн албан тушаалын цалингийн 30 хувиар нэмэгдэл тооцож олгосон 3 сард ноогдох цалин 1.9 сая төгрөг;
- Чингэлтэй дүүргийн Прокурорын газар нь 14.2 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн
- УЕПГ-ын тамгын хэлтэс нь зардлын эдийн засгийн ангилал зөрчин хангамж бараа материалын зардлаас автобусны лизингийн төлбөрт 14.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 1,040.0 сая төгрөг болж, өмнөх оноос 453.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	67.3	62.2	(5.1)
Татаас, санхүүжилтийн авлага	23.3	605.9	582.6
Байгууллагаас авах авлага	496.3	371.8	(124.5)
Дүн	586.9	1,040.0	453.1

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Ахмадын сангийн зарцуулаагүй үлдэгдлийг Сангийн яам 2025 оны эцэст татан төвлөрүүлсэн 605.6 сая төгрөгийг татаас, санхүүжилтийн авлага, Бөртэ ТӨҮГ-аас авах 365.6 сая төгрөг, Дорноговь аймгийн прокурорын газрын 57.2 сая төгрөг, ажилчидтай холбоотой 2.2 сая төгрөг, татвар, нийгмийн даатгалын байгууллагаас авах 4.1 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Орхон аймгийн прокурорын газар нь албан хаагчдад урьдчилгаа цалинг өндөр дүнгээс олгосноос шалтгаалж 3.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцооноос 0.1 сая төгрөгөөр татварыг илүү тооцоолон хөнгөлсөн,
- Нийслэлийн прокурорын газар нь ажилчдын цалингаас тооцсон НДШ болон ХХОАТ-ын авлагыг данс бүртгэлд 1.4 сая төгрөгийн зөрүүтэй тусгасан;
- Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын прокурорын газар Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс шалтгаалан тооцооллын алдаа гарган НДШ-ийн 1.1 сая төгрөг, ажилчидтай холбоотой 0.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар нь 0.1 сая төгрөгийн ажиллагсдын цалинтай холбоотой авлагыг зөрүүтэй тусгаж тайлагнасан;
- Төв аймгийн Прокурорын газар нь тайлант онд 0.4 сая төгрөгийн байгууллагатай холбоотой авлага үүсгэсэн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 26.9 сая төгрөг болж, өмнөх оноос 142.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	169.4	26.9	(142.5)
Дүн	169.4	26.9	(142.5)

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд Улсын Ерөнхий прокурорын Тамгын хэлтсийн МИАТ ХК-ийн 18.7 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын өмнөх оны урьдчилгааны үлдэгдэл 8.2 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Улсын прокурорын Хэрэг эрхлэх газрын тамгын хэлтэс нь МИАТ ХК тай 2023 онд тасалбарын урьдчилгаа төлбөрт шилжүүлсэн 18.7 сая төгрөг тайлант оны эцэст анхан шатны баримтаар баталгаажиж хаагдаагүй үлдэгдэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,875.4 сая төгрөг болж, өмнөх оноос 38.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1.8	1.8	0.0
Тусгай зориулалттай материал	1.8	1.8	0.0
Хангамжийн материал	2,774.6	2,871.1	96.5
Бичиг хэргийн материал	157.6	117.1	(40.5)
Аж ахуйн материал	616.8	551.5	(65.3)
Сэлбэг хэрэгсэл	67.3	83.1	15.8
Түлш, шатах тослох материал	91.1	93.4	2.3
Барилгын засварын материал	14.1	23.4	9.3
Бусад хангамжийн материал	1,827.7	2,002.5	174.8
Мал амьтад	60.3	2.5	57.8
Дүн	2,836.8	2,875.4	38.6

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл тайлант онд худалдан авсан 3,529.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 7.9 сая төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 46.7 сая төгрөгийн бараа материалыг хандив тусламжаар, Дорнод аймгийн прокурорын газрын малын 1.3 сая төгрөгийн нас дэвшилт, 12.6 сая төгрөг шатахууны хөнгөлөлтийг Улсын Ерөнхий прокурорын газарт тус тус бүртгэснээр нэмэгдсэн байна.

Тайланд онд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд үйл ажиллагаандаа 3,499.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт

- Чингэлтэй дүүргийн Прокурорын газар нь 8.9 сая төгрөгийн орлого авч бөөн дүнгээр зарлага гаргасан, эд хариуцагчийн картад бүртгээгүй, хөрөнгийг эзэмшигч тодорхойгүй байна.
- Баянгол дүүргийн Прокурорын газар нь 5.1 сая төгрөгийн худалдан авсан эргэлтийн хөрөнгийн эзэмшигч тодорхойгүй, эд хариуцагчийн бүртгэлд бүртгээгүй, 10.6 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч гэрээнд тодорхой нөхцөл заагаагүй /албан хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудалтай холбоотой/, гэрээ дүгнэсэн акт, үр дүнг тооцсон ажлын тайлан байхгүй, 4.2 сая төгрөгийн цалингийн буцаалтыг авлагаар бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Орхон аймгийн прокурорын газар нь принтерийн засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний 0.1 сая төгрөгийг бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.
- Хан-Уул дүүргийн Прокурорын газар нь 0.8 сая төгрөгийн бараа материалыг ангилал зөрүүлж, аж ахуйн материалыг хангамжийн материалд бүртгэсэн, 6.2 сая төгрөгийн шатахууны шаардах дээр бензин талоны нэгжийн үнэ, тоо ширхэг байхгүй, мөнгөн дүнгээр бичсэн, зөвшөөрсөн дүн байхгүй, жолоочийн авсан шатахууны талоны дүнгээр зардалд бүртгэсэн байна.
- УЕПГ-ын тамгын хэлтэс нь зардлын эдийн засгийн ангилал зөрчин хангамж бараа материалын зардлаас автобусны лизингийн төлбөрт 14.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.
- Тээврийн прокурорын газар нь зардлыг бодитой төлөвлөөгүйгээс 2.0 сая төгрөгийн түлш шатахууны нөөц үүсгэсэн байна.
- Багануур дүүргийн прокурорын газар нь бараа материалын дэлгэрэнгүй тайлангаас харахад хангамжийн материалыг ангилал 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, 3 автомашинтай боловч албаны ажилд хувийн автомашин хэрэглэж, шатахууны зардалд 0.7 сая төгрөг гаргасан;
- Баянзүрх дүүргийн прокурорын газар нь хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүй шаардах хуудсан дээр олгосон нярав, хүлээн авсан хүний гарын үсэг, тайланг хянасан нягтлан бодогчийн гарын үсэггүй 4.9 сая төгрөг;
- Нийслэлийн Прокурорын газар нь 18.4 сая төгрөгийг шатахууны шаардах дээр бензин талоныг нэгжийн үнэ, тоо ширхэг бичээгүй, зөвшөөрсөн дүнгүй, шатахууныг бодит зарцуулалтаар нь зардалд бүртгээгүй, 7.5 сая төгрөгөөр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургалт зохион байгуулахдаа хоол хүргэлтийн катеринг үйлчилгээг авсан, 4.3 сая төгрөгийн шатахууныг автомашины хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, нормтой сэлбэг хэрэгсэл, дугуйг хүлээлгэж өгсөн огноо, спидометрийн заалтыг тэмдэглээгүй;
- Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар нь 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн;
- Сүхбаатар аймгийн прокурорын газар нь төсвөөс батлагдаагүй 0.6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан;
- Сүхбаатар дүүргийн Прокурорын газар нь 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн;
- Сэлэнгэ аймгийн Прокурорын газар нь 0.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн;

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 39,649.5 сая төгрөг болж, өмнөх оноос 25,766.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	13,883.0	39,649.5	25,766.5
Дүн	13,883.0	39,649.5	25,766.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд ТӨБЗГ-ын 2017 оны 09 дүгээр тогтоолоор балансаас баланст шилжиж ирсэн Хан-Уул дүүрэгт байрлах Прокурорын нэгдсэн барилга 18,875.2 сая төгрөг, Эрүүгийн хэргийн төв архив 9,498.6 сая төгрөг, Ахмадын өргөөний 2,520.4 сая төгрөг, Булган аймгийн прокурорын барилга 2,091.1 сая төгрөг, Сүхбаатар аймгийн прокурорын барилга 3,975.6 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан харьяа байгууллагуудад

шилжүүлэхээр зорилготой 2,688.6 сая төгрөгийн хөрөнгө, нийт 39,649.6 сая төгрөгийн барилга байгууламж, хөрөнгө бүртгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хөрөнгө оруулалтын төсөвт 4 барилга байгууламж барих 26,036.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 270.3 сая төгрөгийн бараа материалын нөөцөөс шилжүүлснээс шалтгаалан 25,766.5 сая төгрөгөөр өссөн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 78,116.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,533.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	71,303.8	73,331.8	2,028.0
Барилга, байгууламж, орон сууц	53,458.7	52,733.5	(725.2)
Авто-тээврийн хэрэгсэл	5,482.5	8,098.6	2,616.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,320.5	8,184.9	828.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,798.4	4,110.9	(687.5)
Бусад үндсэн хөрөнгө	230.6	190.7	(39.9)
Ном	13.1	13.1	0.0
Биет бус хөрөнгө	4,279.2	4,785.1	505.9
Программ хангамж	59.1	43.0	(16.1)
Бусад биет бус хөрөнгө	4,220.1	4,742.1	522.0
Дүн	75,583.0	78,116.9	2,533.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Биет хөрөнгө тайлант онд өсөхөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар салбарын хэмжээнд 3,085.1 сая төгрөгөөр автомашины худалдан авсан, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын прокурорын газар нь 268.7 сая төгрөгийн конторын гадна фасад засварыг капиталжуулан бүртгэсэн, Орхон аймгийн прокурорын газар албаны орон сууцыг 220.6 сая төгрөгөөр дахин үнэлсэн нь нөлөөлсөн байна.

Бусад биет бус хөрөнгө өсөхөд Улсын ерөнхий прокурорын 2025 оны А/117 дугаар тушаалын дагуу Ховд аймгийн прокурорын газар 11.0 сая төгрөгийн газар эзэмших эрхийг нэмж бүртгэсэн, Баянгол дүүргийн прокурорын газар эзэмшил газрыг 28.6 сая төгрөгөөр залруулж, Улсын ерөнхий прокурорын А/122 дугаар тушаалаар Нийслэлийн Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар нь 81.5 сая төгрөгийн газар эзэмших эрхийг нэмж тус тус бүртгэсэн, Улсын ерөнхий прокурорын А/151 тушаалаар windows 11, office 2024 үйлдлийн системийг 423.0 сая төгрөгөөр бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд худалдан авсан 1,856.7 сая төгрөг, хандиваар авсан 14.0 сая төгрөг, шилжүүлж авсан 6,758.0 сая төгрөг, бусад 309.9 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 2,383.4 сая төгрөг, нийт 11,322.2 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 718 дугаар тогтоолоор 1,191.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан, 2,787.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, дахин үнэлгээний хорогдол 2,457.2 сая төгрөг нийт 6,457.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн прокурорын газрын эзэмших эрхтэй, санхүүгийн тайланд бүртгээгүй, нийт 2400 м2 бүхий 2 газраа ТЕЗ-ийн зөвшөөрлөөр ажилчдад хөнгөлөлттэй үнээр орон сууц олгох нөхцөлтэйгөөр хувийн хуулийн этгээдэд шилжүүлэх бартерын гэрээг байгуулсан, тус үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй;
- Нийслэлийн Прокурорын газар нь ажилчдын зуслангийн болон амины сууцны 100,000 м.кв газар /газрын өртөг 696.0 сая төгрөг/ нь цахим бүртгэлд бүртгэгдээгүй, 2018 оноос хойш газрын гэрээ, гэрчилгээ шинэчлэгдээгүй бөгөөд прокурорын ажилтан, албан хаагчдын нэр дээр газрын кадастрын зураг нь давхар бүртгэгдсэн, Барилгын хувийн хэрэгт барилгын план зураг болон гаднах зургийг хавсаргаагүй, жил бүрийн засварын ажлуудыг тэмдэглээгүй;

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,095.8 сая төгрөг болж, өмнөх оноос 941.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.5	0	(0.5)
Зээлийн хүүгийн өглөг	0.0	0.0	0.0
Байгууллагад төлөх өглөг	49.1	321.9	272.8
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	3,899.7	2,711.0	(1,188.7)
Санхүүгийн зээл	88.1	62.9	(25.2)
Дүн	4,037.4	3,095.8	(941.6)

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл тайлант онд эрүүгийн хэргийн 2,105.0 сая төгрөгийн барьцааны дүнгээр нэмэгдсэн бол 3,294.5 сая төгрөгийг барьцааг чөлөөлснөөс шалтгаалан 1,188.7 сая төгрөгөөр буурсан байна.

Байгууллагад төлөх өглөг данс тайлант онд хөрөнгө оруулалтын тендерийн барьцааны өглөг 248.0 сая төгрөг, татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлөх өглөг 64.3 сая төгрөг, нийт 272.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Урт хугацаат өр төлбөрийн дансанд АСЕМ-ийн хүрээнд бэлтгэсэн автобусны лизингийн гэрээний 62.9 сая төгрөгийн санхүүгийн зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Төв аймгийн прокурорын газар нь тайлант онд 0.4 сая төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өр төлбөр үүсгэсэн;
- Тээврийн прокурорын газар нь нийгмийн даатгалын шимтгэлийн 3.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 121,623.9 сая төгрөг болж, өмнөх оноос 27,767.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	16,772.9	16,898.8	125.9
Хуримтлагдсан үр дүн	72,363.0	100,006.1	27,643.1
Өмнөх үеийн үр дүн	62,248.3	72,328.7	10,080.4
Тайлант үеийн үр дүн	10,114.7	27,677.4	17,562.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,720.2	4,719.1	(1.1)
Дүн	93,856.1	121,623.9	27,767.8

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны өсөлтөд харьяа байгууллагуудын тайлант оны хуримтлагдсан үр дүн 27,677.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Засгийн газрын оруулсан капитал 125.9 сая төгрөгөөр өссөн нь шинээр 92.5 сая төгрөгийн газар эзэмшилдээ авсан, 33.4 сая төгрөгийн газрыг дахин үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд 214,271.2 сая төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, саналыг Улсын Их Хурал, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 13,135.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 43,567.7 сая төгрөгөөр бууруулж, 157,568.3 сая төгрөгөөр анх баталсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тухай хуульд “Хэмнэлтийн тодотгол” хийж 2025 оны 07 дугаар сард Улсын ерөнхий прокурорын 2025 оны нийт төсөв 145,718.4 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд урсгал үйл ажиллагааны зардал 115,880.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 29,838.1 сая төгрөг болж бууруулан баталсан байна.

Үүнд:

- цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 7,334.2 сая төгрөгөөр,
- ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 625.9 сая төгрөгөөр,
- байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 927.3 сая төгрөгөөр,
- хангамж, бараа материалын зардлыг 2,359.2 сая төгрөгөөр,
- нормативт зардлыг 302.0 сая төгрөгөөр,
- эд хогшил, урсгал засварын зардлыг 3,077.5 сая төгрөгөөр,
- албан томилолт, зочны зардлыг 1,333.0 сая төгрөгөөр,
- бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,604.9 сая төгрөгөөр,
- бараа үйлчилгээний бусад зардлыг 7,098.8 сая төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж 311.6 сая төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

Хөрөнгө оруулалтын зардлын төсвөөс барилга байгууламжийг 11,194.7 сая төгрөгөөр, их засвар зардал 638.1 сая төгрөгөөр, ТЭЗҮ 618.6 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж, тавилгыг 31,116.9 сая төгрөгөөр, нийт 43,567.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг улсын төсвөөс 145,718.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 145,474.3 сая төгрөгийн санхүүжилт авч 142,671.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 142,671.2 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,750.0 сая төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 0.1 сая төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг 3.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийг 264.5 сая төгрөгөөр, Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах зардлыг 1.5 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 1.9 сая төгрөгөөр, байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 23.6 сая төгрөгөөр, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг 1.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/сая төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70703	Прокурорын хяналт	145,718.3	142,671.2	3,047.1	97.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	112,202.3	109,452.2	2,750.1	97.6
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	15.8	15.7	0.1	99.5
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	439.3	435.6	3.7	99.2
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,932.5	1,668.0	264.5	86.3
80811	Нүүлгэн шилжүүлэх зардал	2.8	2.8	-	100
81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	544.4	543.1	1.3	99.7

82315	Байцаан шийтгэх ажиллагаа	462.3	438.8	23.5	94.9
82324	Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	280.6	278.6	2.0	99.3
80918	Бусад /Хөрөнгө оруулалт/	29,838.3	29,836.4	1.9	99.9

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 11. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт		Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Үр дүн
Прокурорын хяналт					
7.1.1	Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.	2021	1	1	1
7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина.	2021	7,407	7,500	7,751
7.1.3	Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.	2021	2,698,521	2,650,000	4,831,351

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан зорилтот түвшин, арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар үнэлж тайлагнасан байна. Үүнд:

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажлыг авч үзвэл гомдол мэдээлэлд хяналт тавьсан дүн өмнөх оноос 1.8 хувиар, хэрэг бүртгэлд хяналт тавьсан дүн 31.2 хувиар, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт хэрэгжүүлсэн дүн 12.3 хувиар тус тус өсөж, зорилтот түвшний биелэлт 103.0 хувь;
- Ял эдлүүлэх ажиллагаанд буюу хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих ажил тайлант онд хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаанд 7751 удаагийн хяналт хэрэгжүүлж, гарсан зөрчлийг шийдвэрлэн ажиллаж, өмнөх оноос 1.2 хувь болон буурсан, зорилтот түвшний биелэлт 100 хувь;
- Улсын хэмжээнд зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил тайлант онд зөрчлийн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлт өмнөх оноос 45.3 хувиар өсөж, зорилтот түвшний биелэлт 182.3 хувиар тус тус хангагдсан байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих” зөрчил өмнөх оноос 1,620,854 буюу 56.2 хувиар өссөнтэй холбоотой байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 145,718.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 142,671.2 сая төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 97.9 хувьтай байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 2,631.9 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 94.2 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 58.5 сая төгрөгийн, нийт 2,784.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 431.9 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 52.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 17.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 180.3 сая төгрөг,

дотоод албан томилолтын зардалд 22.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 260.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,803.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, 1.1 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл” нь Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байхаар заасны дагуу Худалдан авах ажиллагааны тайланг ирүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2025 оны А/14 дугаар тушаалаар “Прокурорын байгууллагын 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөө”-г баталсан байна.

Тус төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 барилга байгууламж барих төсөл, арга хэмжээнд 26,038.7 сая төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 3,810.4 сая төгрөг, урсгал зардлын төсвөөс санхүүжүүлэх урсгал засварын 5 төсөл, арга хэмжээнд 681.6 сая төгрөг, тоног төхөөрөмж үйлчилгээнд 2,633.6 сая төгрөг, нийт 33,164.4 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг тусгасан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 16, тендер шалгаруулалтын онцгой журмаар 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 4 барилга байгууламжийн гүйцэтгэлээр 26,036.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд 26,036.8 сая төгрөгийн хөрөнгө, 3,799.5 сая төгрөгийн бараа материал, нийт 29,836.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор худалдан авах бараа материалын үнэ чанарт судалгаа хийж, хэргийн газрын үзлэг, шинжилгээ, бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход шаардагдах нормын хувцсыг 117.6 сая төгрөгөөр Бөртэ ТӨҮГ-аар хийлгэж, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд 242.5 сая төгрөгийн албан балансыг хэвлэсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн судалгаагаар 2023.10.23-ны өдрийн Б/768 тоот тушаалаар нэг хүнд ногдох өдрийн хоол 15.0 мянган төгрөг, унаа 2.0 мянган төгрөгөөр баталж тайлант онд 5,565.3 сая төгрөгийн төсөв батлагдаж 4,805.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 760.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
- Судалгаагаар ашиглаж байгаа 771.2 сая төгрөгийн 12 программ, лиценз бүртгэлтэйгээс тайлант онд ашиглалтын эрх болон лиценз сунгалтыг урсгал төсвөөс 692.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- Олон улсын прокуроруудын холбооны Зүүн Европ, Төв азийн бүс нутгийн 10 дахь удаагийн хурлыг Монгол улсад зохион байгуулахад Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс ЗГ-ын 251 дүгээр тогтоолоор 1,762.2 сая төгрөг, Прокурорын байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн сургалтад 554.3 сая төгрөгийг урсгал төсвөөс МУЕП-ын 2025 оны А/26 тоот тушаалаар зарцуулсан байна.
- МУЕП-ын 2025 онд батлагдсан орон тоо 1502 албан хаагч, нийт 96,674.0 сая төгрөгийн цалингийн төсөвтэй байснаас тодотголоор 1370 орон тоотой, 90,901.8 сая төгрөгийн төсөвтэй болгон бууруулсан байна. Гүйцэтгэлээр 1315 орон тоотойгоор ажиллаж цалинд 89,026.1 сая төгрөгийг зарцуулж Засгийн газрын 9 хувийн цомхотголоор гүйцэтгэх албан тушаалын 114, үйлчилгээний албан тушаалын 18, нийт 132 орон тоог тус тус хассан байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд тусгай хэрэгцээтэй иргэдэд мэдээ мэдээллийг хүргэхээр дохионы хэлмэрч 1 иргэнтэй 5.4 сая төгрөг, 1 аж ахуйн нэгжтэй 19.8 сая төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон байна.
- Төрд учирсан хохиролтой холбоотой зардал гараагүй, гадаад томилолтын зардал гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсөв захирагчийн үйл ажиллагааг сайжруулах төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит хяналт хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор М.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор А.Даваадорж, аудитын менежер Д.Энхдалай, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 3/1368 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 101,697.6 сая төгрөгийн 1 хувиар буюу 1,016.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд байгууллагуудын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр, бохир усны хэрэглээг хэмнэх, халаалтын нэгдсэн системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, нэгдсэн халаалтын системд холбогдоогүй барилгуудыг тоолууртай болгох чиглэлийг хүргүүлснээр байгууллагын тогтмол зардлыг хэмнэх цахимаар сургалтуудыг зохион байгуулах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг тэвчиж баталсан төсөвт зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

Тайлант онд нийт 1370 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 1315 орон тоотойгоор ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласнаар тайлант онд жирэмсний амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй 28 прокурор, 30 туслах ажилтны түр орон тоонд томилгоо хийгээгүй бөгөөд цалин хөлсний зардлаас 1,875.8 сая төгрөгийн, ажил олгогчоос төллөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 535.1 сая төгрөгийг хэмнэн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт мэдээлэх 889,511.2 сая төгрөгийн 92 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна. Харьяа байгууллагатай холбоотой илэрсэн зөрчлийг аудитын илрүүлэлт хэсэгт орууллаа.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн Прокурорын газар нь шилэн дансны цахим хуудсанд 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн “Ажил гүйцэтгэх гэрээ”, 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” мөн 11, 12 дугаар саруудын хавсралт файлуудыг хугацаа хоцроож мэдээлсэн байна;
- Чингилтэй дүүргийн прокурорын газар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцрон байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудалд 32.8 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Багануур дүүргийн Прокурорын газар 32.8 сая төгрөгийг тайлант жилийн турш бичиг хэрэг, аж ахуйн материал худалдан авахдаа үнийн судалгааг харилцагч байгууллагуудаас авч, албажуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуультай нийцсэн, тендер шалгаруулалт зарлалгүй шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 335.7 сая төгрөгийн зөрчилд өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	335.7	5	335.7	100.0
Нийт дүн	5	335.7	5	335.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төлөвлөлтөөр урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг заагтай төлөвлөх, хөрөнгө оруулалтын шинжтэй зардлыг урсгал зардлаас санхүүжүүлэх асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 968.0 сая төгрөгийн 18 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 142.4 сая төгрөгийн 39 зөрчил² илэрснээс, 0.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 3.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 138.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 34 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 44 байгууллага, ахмадын сан, хөрөнгө оруулалтын данс хамрагдсанаас, 18 байгууллага аудитын түүвэрт хамрагдаж, 26 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан 27 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 142.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 874.5 сая төгрөгөөр бага байгаа тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

5.1 Төсвийн ерөнхийлөн захирагч

5.1.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт 1. Төсвийн хөрөнгийг батлагдсан зориулалт, төлөвлөгөөний хүрээнд зарцуулаагүй, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглахдаа холбогдох хууль, журмын шаардлагыг мөрдөж, үндэслэл, тооцоог бүрэн хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, урсгал төсвийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын шинж чанартай ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх;

2. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой

Илрүүлэлт 2. Аудитаар нийтлэг илэрч байгаа зөрчил нь ажил, гүйлгээ бүрийг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу, холбогдох стандарт, журмын дагуу архивлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу анхан шатны баримтаар бүрэн нотолж, баримтын бүрдлийг иж бүрнээр хангах, мөн баримт бичгийг архивын тухай хууль болон байгууллагын дотоод журамд нийцүүлэн эмх цэгцтэй, бүрэн архивлах дотоод хяналтыг сайжруулах ажиллах;

3. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт 1. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх дотоод хяналт хангалтгүйгээс эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 142.4 сая төгрөгийн 39 зөрчил илэрсэн, зөрчлийг арилгуулахаар 0.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 3.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 138.6 сая төгрөгийн зөрчилд 34 зөвлөмж өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага

5.2.1 Тээврийн прокурорын газар

1. Албан шаардлага

Илрүүлэлт: Төсвийг бодитой төлөвлөөгүй, бараа материалын дансанд 2.0 сая төгрөгийн түлш, шатахууны нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:" 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг бодитой төлөвлөдөггүй, оны эцэст түлш, шатахууны нөөц үүсгэдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Зөвлөмж

Илрүүлэлт: Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 3,658.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсэхээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

5.2.2 Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын Тамгын хэлтэс

Зөвлөмж

1.Илрүүлэлт: МИАТ ХК-д 2021 онд Олон Улсын хурал сургалтад зориулж 101.3 сая төгрөгийг урьдчилгаа төлбөрт шилжүүлснээс тайлант оны эцэст 18.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 43.5 "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Урьдчилгаа төлбөр олгох, зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн авлагад хяналт тавьж ажиллах;

2.Илрүүлэлт: Төсвийн зарцуулалтын эрх нээгээгүй шалтгаанаар хангамж бараа материалын зардлаас автобусны лизингийн төлбөрт 14.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Дүгнэлтийн нэгтгэл

№	Байгууллага нэгжийн нэр	Аудитын код	2025 оны санхүүгийн тайлангийн аудит		Дүгнэлт		Аудит хийсэн байгууллагын нэр
			УАГ	АНАГ	Өөрчлөлтгүй	Түүвэрт	
1	УЕПГ-ын тамгын хэлтэс	САГ-2026/138/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
2	Нийслэлийн прокурорын газар	НТАГ-2026/519/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
3	Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/493/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
4	Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/563/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
5	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/517/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
6	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/518/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
7	Нийслэлийн Хан-Уул дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/519/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
8	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/520/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
9	Нийслэлийн Багануур дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/562/НА-СТА-ТШЗ				1	Нийслэл дэх төрийн аудитын газар
10	Нийслэлийн Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	НТАГ-2026/515/НА-СТА-ТШЗ		1	1		Нийслэл дэх төрийн аудитын газар
11	Архангай аймгийн прокурорын газар	АРА-2026/176/НА-СТА-ТШЗ		1	1		Архангай аймаг дахь төрийн аудитын газар
12	Баян-Өлгий аймгийн прокурорын газар	БӨА-2026/044/НА-СТА-ТШЗ		1	1		Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газар
13	Баянхонгор аймгийн прокурорын газар	БНА-2026/005НА-СТА-ТШЗ		1	1		Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар
14	Булган аймгийн прокурорын газар	БУА-2026/05НА-СТА-ТШЗ		1	1		Булган аймаг дахь төрийн аудитын газар
15	Говь-Алтай аймгийн прокурорын газар	ГАА-2026/112/НА-СТА-ТШЗ				1	Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газар
16	Говьсүмбэр аймгийн прокурорын газар	ГСА-2026/001/НА-СТА-ТШЗ		1	1		Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газар
17	Дархан-Уул аймгийн прокурорын газар	ДАА-2026/11/НА-СТА-ТШЗ		1	1		Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газар
18	Дорноговь аймгийн прокурорын газар	ДГА-2026/111/НА-СТА-ТШЗ				1	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар
19	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дундын прокурор	ДГА-2026/110/НА-СТА-ТШЗ				1	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар
20	Дорнод аймгийн прокурорын газар	ДОА-2026/122/НА-СТА-ТШЗ				1	Дорнод аймаг дахь төрийн аудитын газар
21	Дундговь аймгийн прокурорын газар	ДУА-2026/86/НА-СТА-ТШЗ		1	1		Дундговь аймаг дахь төрийн аудитын газар
22	Завхан аймгийн прокурорын газар	ЗАА-2026/147/НА-СТА-ТШЗ		1	1		Завхан аймаг дахь төрийн аудитын газар
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дундын прокурорын газар	ЗАА-2026/153/НА-СТА-ТШЗ		1	1		Завхан аймаг дахь төрийн аудитын газар

Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

24	Орхон аймгийн прокурорын газар	ОРА-2026/095/НА-СТА-ТШЗ		1	1		Орхон аймаг дахь төрийн аудитын газар
25	Өвөрхангай аймгийн прокурорын газар	ӨВА-2026/03/НА-СТА-ТШЗ		1	1		Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газар
26	Өвөрхангай аймгийн Хархорин сум дундын прокурорын газар	ӨВА-2026/04/НА-СТА-ТШЗ		1	1		Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газар
27	Өмнөговь аймгийн прокурорын газар	ӨМА-2026/140/НА-СТА-ТШЗ		1	1		Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газар
28	Өмнөговь аймгийн Ханбогд сум дундын прокурорын газар	ӨМА-2026/009/НА-СТА-ТШЗ		1	1		Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газар
29	Сүхбаатар аймгийн прокурорын газар	СБА-2026/051/НА-СТА-ТШЗ		1	1		Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газар
30	Сэлэнгэ аймгийн прокурорын газар	СЭА-2026/122/НА-СТА-ТШЗ		1	1		Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар
31	Сэлэнгэ аймгийн Мандал сум дундын прокурорын газар	СЭА-2026/053/НА-СТА-ТШЗ				1	Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар
32	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дундын прокурорын газар	СЭА-2026/137/НА-СТА-ТШЗ				1	Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар
33	Төв аймгийн прокурорын газар	ТӨА-2026/102/НА-СТА-ТШЗ		1	1		Төв аймаг дахь төрийн аудитын газар
34	Увс аймгийн прокурорын газар	УВА-2026/151/НА-СТА-ТШЗ		1	1		Увс аймаг дахь төрийн аудитын газар
35	Ховд аймгийн прокурорын газар	УВА-2026/151/НА-СТА-ТШЗ				1	Ховд аймаг дахь төрийн аудитын газар
36	Ховд аймгийн Булган сум дундын прокурорын газар	ХОА-2026/104/НА-СТА-ТШЗ				1	Ховд аймаг дахь төрийн аудитын газар
37	Хөвсгөл аймгийн прокурорын газар	ХӨА-2026/035/НА-СТА-ТШЗ		1	1		Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар
38	Хэнтий аймгийн прокурорын газар	ХЭА-2026/173/НА-СТА-ТШЗ				1	Хэнтий аймаг дахь төрийн аудитын газар
39	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дундын прокурорын газар	ХЭА-2026/076/НА-СТА-ТШЗ				1	Хэнтий аймаг дахь төрийн аудитын газар
40	Прокурорын байгууллагын хөрөнгө оруулалт	САГ-2026/223/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
41	УЕПГ-ын дэргэдэх сургалт судалгааны хүрээлэн	САГ-2026/232/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
42	УЕПГ-ын дэргэдэх Эрүүгийн хэргийн тусгай архив	САГ-2026/224/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
43	Тээврийн прокурорын газар	САГ-2026/222/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
44	Ахмадын сан	САГ-2026/18/НА-СТА-ТШЗ	1			1	Үндэсний аудитын газар
Нийт			6	27	27	17	

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Багануур дүүргийн Прокурорын газар	4	159.4			4	159.4	4	159.4				
2	Баянгол дүүргийн Прокурорын газар	1	561.3			1	561.3	1	561.3				
3	Говь-Алтай аймгийн Прокурорын газар	1	26.7			1	26.7	1	26.7				
4	Говьсүмбэр аймгийн прокурорын газар	1	0.1			1	0.1	1	0.1				
5	Нийслэлийн Прокурорын газар	3	47.1			3	47.1	3	47.1				
6	Өмнөговь аймгийн прокурорын газар	1	8.8			1	8.8	1	8.8				
7	Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар	1	8.2	1	8.2			1	8.2				
8	Сэлэнгэ аймгийн Прокурорын газар	0	2.5				2.5	1	2.5				
9	Өмнөговь аймгийн Ханбогд сумын прокурорын газар	1	6.0			1	6.0	1	6.0				
10	Хан-Уул дүүргийн Прокурорын газар	2	132.1			2	132.1	2	132.1				
11	Чингэлтэй дүүргийн Прокурорын газар	2	15.8			2	15.8	2	15.8				
	Дүн	17	968.0	1	8.2	16	959.8	18	968.0				

6.3. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ									
1	Монгол Улсын Ерөнхий прокурор	3	-					3	-
	Дүн	3	-	-	-	-	-	3	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ									
1	Багануур дүүргийн Прокурорын газар	2	6.6					2	6.6
2	Баянгол дүүргийн Прокурорын газар	3	19.9					3	19.9
3	Баянзүрх дүүргийн Прокурорын газар	1	4.9					1	4.9
4	Баянхонгор аймгийн прокурорын газар	1	-					1	-
5	Булган аймгийн прокурорын газар	1	0.3	1	0.3				
6	Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	1	0.5					1	0.5
7	Нийслэлийн Прокурорын газар	6	31.7					6	31.7
8	Орхон аймгийн прокурорын газар	3	1.0	1	0.1			2	0.9
9	Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар	2	1.7					2	1.7
10	Сүхбаатар аймгийн прокурорын газар	1	0.6					1	0.6
11	Сүхбаатар дүүргийн Прокурорын газар	1	1.8					1	1.8
12	Сэлэнгэ аймгийн Прокурорын газар	1	0.6					1	0.6
13	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын прокурорын газар	1	1.2			1	1.2		
14	Төв аймгийн Прокурорын газар	1	0.4					1	0.4
15	Хан-Уул дүүргийн Прокурорын газар	3	7.0					3	7.0
16	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын Прокурорын газар	2	0.2	1	0.2			1	-
17	Ховд аймгийн Прокурорын газар	1	1.9					1	1.9
18	Чингэлтэй дүүргийн Прокурорын газар	2	23.2					2	23.2
19	УЕПГ-ын тамгын хэлтэс	4	33.2					4	33.2
20	Тээврийн прокурорын газар	2	5.6			1	2	1	3.6
	Дүн	39	142.4	3	0.6	2	3.2	34	138.6
	Нийт дүн	42	142.4	3	0.6	2	3.2	37	138.6

6.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ								
Нийслэлийн Прокурорын газар	1	-					1	-
Чингэлтэй дүүргийн Прокурорын газар	1	-					1	-
Дүн	2	-					2	-
БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ								
Багануур дүүргийн Прокурорын газар	1	32.8					1	32.8
Дүн	1	32.8					1	32.8
Нийт дүн	3	32.80					3	32.8